

МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ

ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН
САН

ХАГАС
ЖИЛИЙН
ТАЙЛАН

— 2023 —

БИД ТҮҮЧЭЭЛЭХ ЁСТОЙ

МАНДАЛ
ИРЭЭДҮЙН
ӨСӨЛТ



Агуулга

Сангийн танилцуулга	4
Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн танилцуулга	5
Хөрөнгө оруулалтын сангийн бүтэц зохион байгуулалт, засаглал	5
Хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө оруулалтын бодлого, стратеги, эрсдэл, эрсдэлийн удирдлага	8
Хөрөнгө оруулалтын сангийг хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа, түүний гүйцэтгэл	9
Сангийн зардлын харьцаа үзүүлэлт	11
Кастодиан үйлчилгээ үзүүлэгч байгууллагын танилцуулга	12
Нэгж эрх эзэмшигчдийн мэдээлэл	13
Онцлох үйл явдлын тойм	14
Санхүүгийн тайлан	16

САНГИЙН ТАНИЛЦУУЛГА

“Мандал Ирээдүйн Өсөлт Хамтын ХОС” ХХК нь эрсдэлийн удирдлагын нэгдсэн тогтолцоог хэрэгжүүлэх замаар олон нийтээс татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг өөрийн бодлогын баримт бичиг болон хууль тогтоомжийн хүрээнд, мэргэжлийн түвшинд үр ашигтай хөрөнгө оруулалт хийх замаар үнэт цаасны зах зээлээс олсон өгөөжийг хөрөнгө оруулагчдадаа хүртээх зорилго бүхий мэргэжлийн хөрөнгө оруулалтын хуулийн этгээд юм.

Байгуулагдсан огноо

2021.08.20

Бүртгэлтэй арилжаа эрхлэгч байгууллага

“Монголын Хөрөнгийн Бирж” ХК

Хөрөнгө хадгалж буй байгууллага

Голомт банкны Кастодиан үйлчилгээний хэлтэс

Сангийн хэлбэр, төрөл

Хамтын хаалттай

Татан төвлөрүүлсэн хөрөнгө

50 тэрбум төгрөг

Хөрөнгө итгэмжлэн удирдах компани

“Мандал Ассет Менежмент ҮЦК” ХХК

Сангийн үйл ажиллагаа явуулах хугацаа

10 жил

Цэвэр хөрөнгийн үнэ цэн | 2023.06.30

56.03 тэрбум төгрөг

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

“Мандал ассет менежмент ҮЦК” ХХК

Менежментийн компанийн итгэмжлэн удирдах үйлчилгээний жилийн тайлан

Мандал Ирээдүйн Өсөлт Хамтын сантай 2021 оны 6-р сарын 15-ны өдөр байгуулсан менежментийн үйлчилгээ үзүүлэх гэрээний дагуу сангийн хөрөнгийг итгэмжлэн удирдаж байна.

Хөрөнгө оруулалтын менежментийн компани (цаашид "ХОМК" гэх) нь одоогоор 4 төрлийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулж, хөрөнгийг удирдаж буй Монголын томоохон хөрөнгө удирдлагын компанийн нэг юм. Үүнээс 50 тэрбум төгрөгийг “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК (цаашид “Сан” гэх)- аар дамжуулан татан төвлөрүүлж, хууль, дүрэм, журамд заасан хөрөнгө оруулалтын хэрэгслүүдэд хөрөнгөө байршуулан, үйл ажиллагаагаа эрхлэн явуулж байна.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ЗАСАГЛАЛ

Сангийн Төлөөлөн удирдах зөвлөл(цаашид "ТУЗ" гэх) нь сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт Сангийн эрх барих дээд байгууллага юм. Сангийн ТУЗ нь хамтын удирдлага бүхий бүтэцтэй бөгөөд Сангийн нэгж эрх эзэмшигчдийн хөрөнгө оруулалтыг хамгаалах, Санг үр ашигтай шийдвэр гаргах, үйл ажиллагааг хянах, стратегийг тодорхойлох үндсэн чиг үүрэгтэйгээр ажиллав. Мандал Ирээдүйн Өсөлт сангийн ТУЗ нь 5 гишүүний бүрэлдэхүүнтэй ба үүнээс 2 нь хараат бус гишүүнээс бүрдэж байгаа бөгөөд хараат бусаар Сангийн нэгж эрх эзэмшигчдийн эрх ашгийг нэн тэргүүнд тавин ажиллаж байна.

Хүснэгт 1. ТУЗ-ийн гишүүд.

Р.Амаржаргал	ТУЗ-ийн дарга
Н.Монсор	ТУЗ-ийн гишүүн
Г.Батзориг	ТУЗ-ийн гишүүн
Ц.Батсүх	ТУЗ-ийн хараат бус гишүүн
Ч.Анхбаяр	ТУЗ-ийн хараат бус гишүүн



Сангийн ТУЗ-ийн дарга:
Р.Амаржаргал

Р.Амаржаргал нь 1978 онд ЗХУ-ын Москва хотын УАААДС-ийг эдийн засагч мэргэжлээр, 1994 онд Брэд Фордын их сургуулийг Макро эдийн засгийн бодлого төлөвлөлтийн магистр зэрэгтэйгээр тус тус төгссөн.

1982 оноос эхлэн МҮЭТЗөвлөлд зааварлагч, 1983 оноос ЦНДС-д багш, 1990 оноос ТИС-д багш, 1991 онд Эдийн Засгийн Колледжын захирал, 1998 онд Засгийн газарт Сайд, 1999 онд Засгийн газарт Ерөнхий сайд, 1996 он, 2004 он, 2008 он, 2012 онд тус тус Улсын Их Хурлын гишүүн албан тушаалуудыг тус тус хашиж байсан.

Сүүлийн 30 гаруй жилийн хугацаанд улсад өөрийн үнэтэй хувь нэмрээ оруулан ажиллаж байна.



Сангийн ТУЗ-ийн гишүүн:
Г.Батзориг

Г. Батзориг нь “Мандал Санхүүгийн Нэгдэл” ХХК-ийн ерөнхий эдийн засагч бөгөөд өмнө нь “Грандлайн БДК”-н хөрөнгө оруулалтын шинжээч, Хас Банканд зээлийн багцын аналит, макро эдийн засгийн шинжээч, Голомт Банканд макро эдийн засагч, ахлах эдийн засагчаар тус тус ажиллаж байв. Тэрээр дэлхийн болон Монголын эдийн засаг, макро эдийн засгийн судалгааны ажилд оролцож байсан.

Тэрээр МУИС-ийн Эдийн засгийн сургуулийг эдийн засагч мэргэжлээр бакалавр, Турк улсад Сакаръя их сургуульд эконометрик, эдийн засгийн чиглэлээр магистр хамгаалсан.



Сангийн ТУЗ-ийн гишүүн:
Н.Монсор

Н.Монсор нь Шинжлэх ухаан компьютерын сургуулийг төгссөн, программ хангамжийн магистр зэрэгтэй.

2009 оноос хойш үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалтын чиглэлээр дагнан ажилласан туршлагатай бөгөөд үл хөдлөх хөрөнгийн санхүүгийн менежментийн чиглэлээр Хонгконг-д мэргэжил дээшлүүлсэн.

2011 оноос хойш үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалтын менежментийн чиглэлээр дагнан ажиллаж байгаа бөгөөд нийт 150 тэрбум төгрөгийн үл хөдлөх хөрөнгийг амжилттай удирдаж байна.



Сангийн ТУЗ-ийн
хараат бус гишүүн:
Ц.Батсүх

Ц.Батсүх нь Монголын улсын тэргүүлэх эдийн засагчдын нэг юм.

Тэрээр СЭЗИС-ийн тэнхимийн профессор бөгөөд Монголбанкны мөнгөний бодлогын зөвлөлийн хараат бус гишүүнээр ажилладаг. Ц.Батсүх нь хэрэглээний математикийн шинжлэх ухааны магистр, эдийн засгийн ухааны доктор (Ph.D) профессор цолтой.

Өнгөрсөн хугацаанд эдийн засгийн чиглэлээр олон тооны төсөлд зөвлөх хийж байсан ба эдийн засгийн нөхцөл байдлын тухай тогтмол ярилцлага өгдөг билээ.



Сангийн ТУЗ-ийн
хараат бус гишүүн:
Ч. Анхбаяр

Ч. Анхбаяр нь 2006-2011 онд Хадгаламж, Тээвэр хөгжлийн банк болон Анод банканд эрсдэлийн удирдлагын газрын захирал, 2012-2016 онд Мандал Даатгал компанийн ахлах менежер, 2016-2017 онд Азийн Хөгжлийн Банкны төсөлд зөвлөх, 2018 оноос одоог хүртэл МУИС-Бизнесийн сургуульд ахлах багшаар ажиллаж байна.

Ч.Анхбаяр нь Монгол Улсын Их сургуулийн Хэрэглээний шинжлэх ухааны сургуулийг хэрэглээний математикийн магистр, бизнесийн удирдлагын докторын зэрэгтэй.

Дотоод хяналт

Сангийн ТУЗ нь доороо дотоод хяналтын хороотой байх ба ТУЗ-өөс томилогдож өөрийн үйл ажиллагааг ТУЗ-д тайлагнадаг. Дотоод хяналтын хороо нь Сангийн үйл ажиллагаа, сангийн менежерийн үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэх, кастодианы үйл ажиллагаанд хяналт тавин ажилладаг нэгж юм.

Хүснэгт 1. ТУЗ-ийн гишүүд.

Г.Гантулга	Дотоод хяналтын хорооны дарга
Б.Энхтүвшин	Дотоод хяналтын хорооны гишүүн
Г.Батзориг	Дотоод хяналтын хорооны гишүүн

Дотоод хяналтын хороо нь хяналтыг төлөвлөгөөт ба төлөвлөгөөт бус хэлбэрээр явуулдаг. Төлөвлөгөөт хяналтыг Сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлаас жилд нэг удаа батлах бөгөөд Дотоод хяналтын хороо нь уг төлөвлөгөөнд заасан хугацаанд хяналт шалгалтын үйл ажиллагааг гүйцэтгэдэг.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГО, СТРАТЕГИ, ЭРСДЭЛ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Хөрөнгө оруулалтын бодлого

Сангийн хөрөнгө оруулалтын бодлого нь “Income investing” буюу “тогтмол орлого” болон “growth investing” буюу “хөрөнгийг өсгөх” гэсэн хосолмол аргад суурилдаг. Сан нь зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан хөрөнгө оруулалтуудыг эрсдэлийн зохих түвшинд барин, өгөөжийг өндөр байлгахад зорин ажиллаж байгаа бөгөөд хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичгийн хүрээнд мэргэжлийн судалгаа шинжилгээний үндсэн дээр хөрөнгө оруулалтууд хийж ажиллаж байна. Сангийн хөрөнгө оруулалтын багцын дийлэнх хувийг хувьцаа болон тогтмол орлоготой үнэт цаасанд, үлдсэн хэсгийг мөнгөний захын хэрэгсэлд байршуулаад байна.

Хөрөнгө оруулалтын эрсдэл

Хөрөнгө оруулалтын эрсдэлийн хүрээнд бид хөрөнгө оруулалтын багцын эрсдэлийг тооцож, тараан байршуулалт хийж ажиллаж байна. Хөрөнгө оруулалтын судалгаанд эрсдэлийн үнэлгээг заавал тооцдог ба эрсдэлийн удирдлагын олон жилийн туршлагатай баг хамт олон хөрөнгө оруулалтын шийдвэрийг гаргадаг.

Зах зээлийн болон сангийн үйл ажиллагааны эрсдэл

Сан үйл ажиллагаа явуулахад хүний нөөц, ашиглаж буй систем дотоод дүрэм журам болон зах зээлээс нөлөөлж болохуйц үйл ажиллагаатай холбоотой эрсдэлүүд хамаарна. Тухайлбал, хүнээс хамаарах үйл ажиллагааны алдаа, технологийн доголдол болон хууль эрх зүйтэй холбоотой эрсдэлүүд багтдаг. ХОМК-ийн хүний нөөцийн эргэц бага, олон жилийн туршлагатай мэргэжилтнээс бүрдэж байгаа нь үйл ажиллагааны эрсдэлийг удирдах түлхүүр болж байна.

Сангийн удирдаж буй хөрөнгийн үнэлгээ эдийн засаг, улс төр, санхүү болон нийгмийн эрүүл мэндтэй холбоотой (халдварт өвчин, цар тахал гэх мэт) эсхүл зах зээлд өрнөж буй үйл явдлаас шалтгаалан өсөх, буурах зэрэг хэлбэлзэж болно. Дээрх дурьдсан үйл явдлаас шалтгаалсан гэнэтийн өөрчлөлтийг урьдчилан таамаглах, төсөөлөх нь хүнд сорилт байдаг. ХОМК нь нийгэм эдийн засгийн өдөр тутам хувьсан өөрчлөгдөж буй орчинд тохируулан богино хугацаанд хөрөнгө оруулалт ба үйл ажиллагааны оновчтой шийдвэрүүдийг судалгаа шинжилгээнд суурилан үйл ажиллагаагаа явуулж байна.

Тодруулбал:

Хүүгийн түвшний эрсдэл:

Зах зээл дэх хүүгийн түвшин өөрчлөгдөх нь Сангийн мөнгөн хөрөнгийн хадгаламжийн өгөөжийн түвшинд нөлөөлнө. Иймд хүүгийн түвшний өөрчлөлт таамаглалыг улирал бүр шинэчилж, тогтвортой үйл ажиллагаатай, эрсдэл даах чадвар өндөр банкыг харилцагчаар сонгож үйл ажиллагаагаа явуулж байна.

Инфляцийн эрсдэл:

Сангийн хөрөнгө болон хөрөнгө оруулалтаас олох өгөөж нь ирээдүйн инфляцийн түвшин, мөнгөний үнэ цэнийн утгаас хамааран бодит утгаараа төлөвлөсөн хэмжээнээс бага байх эрсдэл бий. Инфляцийн өсөлт нь эдийн засгийн бусад хүчин зүйлст нөлөөлөх ба үнэт цаасны бодит үнэ цэнд нөлөөлнө. Сан нь инфляци, эдийн засгийн загварын таамаглал ашиглан ирээдүйн инфляцийн түвшинг тооцдог.

Валютын ханшийн эрсдэл:

Ханшийн хэлбэлзэл нь зах зээлд тодорхой бус байдлыг нэмэгдүүлж эдийн засгийн үйл хөдлөлийн зардлыг ихэсгэдэг. Иймд ханшийн таамаглал эрсдэлийг тооцон ажиллаж байна.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙГ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТҮҮНИЙ ГҮЙЦЭТГЭЛ

Хөрөнгө оруулалтын гүйцэтгэл

“Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС ХХК /цаашид “Сан” гэх/-ийн нийт хөрөнгө 2023 оны 6-р сарын 30-ны байдлаар 6.03 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 56.03 тэрбум төгрөгт хүрсэн байна. Энэ нь анхны үнэлгээнээс 12.06 хувиар өсжээ.

Цэвэр активын үнэлгээ, нэгж эрхийн үнэ цэн


₮ 56.03 тэрбум

Цэвэр хөрөнгийн
үнэ цэн

₮ 1,120.62

Нэгж эрхийн цэвэр
хөрөнгийн үнэ цэн


График 1 Нэгж эрхийн үнэ | төгрөгөөр



Цэвэр хөрөнгийн үнэ цэн нь хөрөнгө оруулалтын сангийн хувьд нэгж эрхийн үнийг тодорхойлогч гол хүчин зүйл байдаг. Сангийн хувьд тус үзүүлэлт өссөөр байгаа бөгөөд сарын эцэст 1,120.62 төгрөг байна.


Сангийн хөрөнгө оруулалтын багц

График 2. Хөрөнгө оруулалтын багц | хувиар



Сан нь нийт хөрөнгөө хувьцаа, тогтмол орлоготой үнэт цаас, мөнгөний захын хэрэгслүүдэд байршуулж байгаа бөгөөд үүний 44%-ийг тогтмол орлоготой үнэт цаас, 30.6%-ийг хувьцаа, 25.4%-ийг мөнгөний захын хэрэгсэл эзэлж байна.

График 3. Тогтмол орлоготой үнэт цаасны задаргаа | хувиар




Тогтмол орлоготой үнэт цаасны хөрөнгө оруулалтыг задалж харвал 62.9%-ийг олон улсад арилжаалж буй засгийн газрын бондод, 23.9%-ийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасанд, 13.1%-ийг компанийн бондод тус тус хөрөнгө оруулсан байна.

Олон улсад арилжаалж буй Засгийн газрын бонд дотор Монгол Улсын Засгийн Газраас гаргасан Сэнчири, Хүннү, Хуралдай зэрэг бондууд байгаа юм.

АНУ-ын Холбооны Нөөцийн банк сүүлийн жил гаруйн хугацаанд бодлогын хүүгээ удаа дараа нэмэгдүүлж, ам.долларын ханш бусад валютуудын эсрэг чангарч ханшийн эрсдэлийг үүсгээд байна. Иймд хөрөнгө оруулагчдадаа тулгарах энэхүү эрсдэлийг хязгаарлаж, олон улсын зах зээлд арилжаалдаг Монгол Улсын Засгийн Газрын бондуудад ам.доллароор хөрөнгө оруулаад байгаа болно.


График 4. Хөрөнгө оруулалтын бүтэц | салбараар



Сан нийт хөрөнгөө санхүү болон санхүүгийн бусад үйл ажиллагаа, хүнсний үйлдвэрлэл зэрэг салбаруудад тараан байршуулж байна.

САНГИЙН ЗАРДЛЫН ХАРЬЦАА ҮЗҮҮЛЭЛТ

График 5. Сангийн зардлын бүтэц | сая төгрөгөөр



Менежментийн үйлчилгээний зардал

2021 оны 06-р сарын 15-ны өдөр Мандал Ассет Менежмент ҮЦК ХХК нь Сантай менежментийн үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулснаар хөрөнгө оруулалтын сангийн менежерээр томилогдож хөрөнгийг итгэмжлэн удирдаж эхэлсэн. ХОМК-ийн менежментийн үйлчилгээний жилийн шимтгэл нь сангийн нийт цэвэр хөрөнгийн 1%-р тооцогддог бөгөөд тус дүнг сар бүр тэнцүү хуваан төлдөг.

Кастодиан үйлчилгээний шимтгэл

Сангийн Кастодиан банкны үйлчилгээг Голомт банкны кастодиан үйлчилгээний хэлтэс гэрээний дагуу үзүүлдэг. 2023 оны эхний хагас жилийн байдлаар нийт кастодианы үйлчилгээний шимтгэл нь 50.51 сая төгрөг байна.

КАСТОДИАН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГЫН ТАНИЛЦУУЛГА



Кастодианы үйл ажиллагааны жилийн тайлан

Голомт банкны Кастодиан үйлчилгээний хэлтэстэй байгуулсан “Хөрөнгө хадгалах, кастодианы үйлчилгээний гэрээ”-ний дагуу сангийн хөрөнгийг хадгалах, нэгж эрхийн тухайлсан бүртгэлийг хийх, нэгж эрхийн цэвэр үнэлгээг гаргах зэрэг үйлчилгээг үзүүлж байна. Тухайлбал, Голомт банк нь 2023 оны 6-р сарын 30-ны өдрийн байдлаар Мандал Ирээдүйн Өсөлт Хамтын ХОС ХХК-ийн 56.03 тэрбум төгрөгийн хөрөнгийг хадгалж байна.

Нэгж эрхийн тухайлсан бүртгэлийн хувьд Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2-д “хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн тухайлсан бүртгэлийг тухайн санд үйлчилгээ үзүүлж байгаа кастодиан хөтөлнө” гэж заасан байдаг. “Мандал ирээдүйн өсөлт хамтын хаалттай ХОС”-н хөрөнгийг хадгалдаг кастодианы хувиар дээр дурдсан гэрээний хүрээнд Голомт банк нь нэгж эрхийн тухайлсан бүртгэлийг хөтлөх үйлчилгээг үзүүлж байна.

Сангийн нэгж эрх нь Монголын Хөрөнгийн Биржээр арилжаалагддаг бөгөөд нэгж эрхийн төвлөрсөн бүртгэлийг Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв ХХК хөтөлдөг. Голомт банк нь ҮЦТХТ-тэй байгуулсан гэрээний үндсэн дээр нэгж эрхийн өмчлөгчдийн мэдээлэл, тухайлсан бүртгэлийг өдөр тутам тулгалт хийж байна.

Нэгж эрхийн цэвэр үнэлгээг Голомт банкны Кастодиан үйлчилгээний хэлтсээс Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль тогтоомж болон бусад холбогдох дүрэм, журмын дагуу тооцоолон гаргаж, Монголын хөрөнгийн биржийн вэбсайтаар дамжуулан өдөр бүр мэдээлэлдэг. 2023 оны эхний хагас жилийн байдлаар Цэвэр хөрөнгийн үнэлгээний мэдээллийг 126 удаагийн тооцоолол хийгдэн сайтад мэдээлэгдсэн.

НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ

Сангийн нэгж
эрх эзэмшигчдийн
тоо:


8,462

1 сая төгрөгөөс доош
хөрөнгө оруулалт хийсэн
хөрөнгө оруулагчдын
эзлэх хувь:

57%

Сан нь Монголын хөрөнгийн биржээр дамжуулан 2021 оны 8-р сарын 4-ны өдөр хүртэл 6,911 хөрөнгө оруулагчаас нийт 50 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг амжилттай татан төвлөрүүлсэн бөгөөд 2023 оны 6-р сарын 30-ны өдрийн байдлаар нийт 8,462 сангийн нэгж эрх эзэмшигчтэй болсон байна. Үүнээс дийлэнх хувийг буюу 57 хувийг 1 саяас доош дүнгээр хөрөнгө оруулсан нэгж эрх эзэмшигчид эзэлж байгаа бөгөөд энэ нь хөрөнгө оруулагчид бага дүнгээр хөрөнгө оруулж, мэргэжлийн байгууллагаар дамжуулан хөрөнгийн зах зээл дээр байгаа олон төрлийн бүтээгдэхүүнүүдэд эрсдэл багатайгаар хөрөнгөө өсгөх сонирхолтой байгааг илтгэж байна.


График 6. Хөрөнгө оруулагчид | хүйсээр



2023 оны 6-р сарын 30-ны байдлаар санд нийт 8462 хөрөнгө оруулагч хөрөнгө оруулсан бөгөөд 56% нь эмэгтэй, 44% нь эрэгтэй хөрөнгө оруулагчид байна.

13

График 8. Эзэмшиж буй нэгж эрхийн тоо | насаар



Нийт нэгж эрхийн хамгийн их буюу 30%-г 36-45 насныхан эзэмшиж байгаа бол хамгийн бага буюу 6%-г 25 болон түүнээс доош насныхан эзэмшиж байна.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛЫН ТОЙМ

1. Монголын хөрөнгийн зах зээлийн түүхэн үйл явдал болох Системийн нөлөө бүхий 5 банкны IPO амжилттай болж өнгөрлөө. Мандал Ирээдүйн Өсөлт Хамтын хөрөнгө оруулалтын сан нь Банкны IPO-д идэвхтэй оролцож, сангийн 8500 хөрөнгө оруулагчид маань Төрийн банк, Голомт банк, Хаан банк болон Худалдаа Хөгжлийн Банкны эзэд болоод байна.
2. Мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор сангийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг хөрөнгө оруулагчдад сар бүр тайлагнаж байна.
3. Нэгж эрх эзэмшигчдийн хурлыг 2023 оны 4-р сарын 22-ны өдөр амжилттай зохион байгуулав. Хөдөө орон нутаг, гадаад улсад ажиллаж амьдардаг хөрөнгө оруулагчдын оролцооны тэгш байдлыг хангахын тулд хурлын материалыг сошиал орчинд байршуулж, онлайн хэлбэрийг сонгосон болно.

МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН

МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН

НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

14

4. Монголын хамгийн том хөрөнгө оруулалтын экспог 2023 оны 4-р сарын 29-ны өдөр Шангри-Ла-д 2 дахь жилдээ амжилттай зохион байгуулж, нийт 5000 хөрөнгө оруулагч бүртгүүлэн, оролцоо. ӨСГӨХ ҮҮ уриан дор зохион байгуулагдсан энэ удаагийн экспогоор ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ӨРХИЙН санхүү рүү чиглэснээрээ онцлогтой бөгөөд санхүүгийн зах зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээ, мэдээлэл зөвлөгөөг хүргэн ажиллав.



5. Энэ удаагийн экспогийн онцлох арга хэмжээ болох "ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ЭЭЖ" арга хэмжээ 2023 оны 6-р сарын 07-ны өдөр зохион байгуулагдлаа.

Энэхүү арга хэмжээнд оролцсон хөрөнгө оруулагч эзжүүдийг Хөрөнгө оруулалтын зөвлөгөө, мэдээллээр хангахаас гадна үнэт цаасны данс үнэгүй нээлгэх, Санхүүгийн философи болон Менежментийн Психологи зэрэг санхүүгийн номуудыг хөнгөлөлттэй авах боломжуудыг бүрдүүлж өгсөн зэрэг онцлогтой байв.



6. Харилцагчийн төв нь хөрөнгө оруулагчдад үнэ төлбөргүй санхүүгийн зөвлөгөө өгөх, тэдэнд тулгарсан аливаа асуудлыг шуурхай шийдвэрлэн ажиллаж байна. Хөрөнгө оруулагчийн зүгээс Мандал Ирээдүйн Өсөлт сангийн нээлттэй мэдээлэлд хандах, түүнтэй танилцах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байгаа болно.

15



**Та бидэнтэй холбогдохыг хүсвэл
7575-9911 утсаар холбогдоно уу.**

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

	сая төгрөгөөр
Үзүүлэлт	6/30/2023
Мөнгө	6,738
Авлага	17,365
Санхүүгийн хөрөнгө	32,508
УТЗ	-
Нийт хөрөнгө	56,611
Дансны өглөг	150
Татварын өр	1
Хойшлогдсон татварын өр	213
Бусад	5
Нийт өр төлбөр	369
Өмч	50,000
Эздийн өмчийн бусад хэсэг	(551)
Хуримтлагдсан ашиг	6,793
Эздийн өмчийн дүн	56,242
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	56,611

ОРЛОГЫН ТАЙЛАН

	сая төгрөгөөр
Үзүүлэлт	6/30/2023
Хүүний орлого	1,984
Ногдол ашгийн орлого	554
Олз	791
Нийт ашиг (алдагдал)	3,329
Ерөнхий ба удирдлагын зардал	407
Бусад зардал	19
Нийт зардал	426
Татварын өмнөх ашиг (алдагдал)	2,903
Орлогын татварын зардал*	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	2,903

* 2022 оны 11 сарын 11-ний өдөр “Аж Ахуйн Нэгжийн Орлогын Албан Татварын Тухай” хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтийн хүрээнд 21.1.15-д “Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны орлого”-ыг татвараас чөлөөлөх заалт оруулсан болно.

МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН

Утас: +976-75759911
Имэйл: support@mandalasset.mn